

АСГАТ СУМЫН 2022 ОНЫ 5 САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 06 сарын 27-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

10 жилд 1 удаа явагддаг хөдөө аж ахуйн тооллогод сумын хэмжээнд 174 өрхөөс судалгаа асуулга авч ажилласан. Аймгийн ИТХ-ын ажлын албаны санаачлагаар Уулбаян сумын ИТХ-ын ажлын албатай хамтарсан туршлага солилцох сургалтанд хамрагдсан байна. Байгууллагынхаа өдөр тутмын ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн хариутай албан бичгийн хариуг цаг хугацаанд нь холбогдох газарт нь хүргүүлж байна. Байгууллагынхаа эд хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн өмчийн газарт тайлан тооцоо явуулаад байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын санаачлагаар сумынхаа баруун талд ногоон төгөл байгуулах ажлыг эхлүүлээд хашааг нь бүрэн татаж дуусган 1500 ширхэг мод тарьж суулгалаа.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц,

2022 оны шинээр өмчлүүлэх газрын 64 нэгж талбарын эргэлтийг цэгийг газар дээр нь зоолгож хар зураасыг тавьж ажилласан үүний дагуу шинээр өмчлөх 8 өргөдөл , эзэмших 2 өргөдөл хэмжээ талбайг өөрчлөх 4 өргөдөл өргөдөл авч шийдвэрүүлсэн

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Аймгийн засаг даргын захирамжын дагуу 10 жилд 1 удаа явагддаг хөдөө аж ахуйн тооллогын ажилд оролцон сумын хэмжээнд 174 өрхөөс судалгаа асуулга авч ажилласан. Зун намрын бэлчээрт уст цэгийн хайгуул хийлгэх 3-н газрыг сонгож судалгааг ХАА-н газарт хүргүүлэн , уст цэгийг тогтоолгосон.

Төмс хүнсний ногоо тариаллуулах ажлын хүрээнд 1-тн үрийн төмс , нарийн ногооны үрийг иргэдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулсан нийт өртөг 800.000 төгрөгөөр, Төмс хүнсний ногоог 3-н албан байгууллага, Аж ахуй нэгж 1 ,иргэд 10 өрх тариалалт хийгээд байна.

Үхрийн арьс товруудах өвчин Дорнод аймгийн Баянтүмэн суманд оношлогдсон тул өөрийн сумын эрсдэлтэй 18 өрхөөр тандалт хийж цахим системд оруулж ,малын хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна. Шүлхий өвчний тандалт хийж дээж материалыг аймгийн мал эмнэлгийн газрын лабораторт хүргүүлсэн.

Байгаль орчин:

Шарга ХХК-тай хамтран нэгдсэн хогийн цэгийг 0,5га талбайн хогийг түрүүлж цэгцэлэх ажлыг 2 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн. Бүх нийтийн цэвэрлэгээг 3 удаа зохион байгуулан 5 байгууллага 2 ААН ,73 айлөрххамрагдаж 21тн хогийг цэвэрлэж сумын өнгө үзэмж сайжирсан.

“Нэг тэр бум мод” үндэсний өдөр"-ийг сумын хэмжээнд өргөн хүрээнд зохион байгуулж 658 иргэн, 5 албан байгууллага оролцож энэ ажлын хүрээнд нийт 4187 модыг тарьж суулгасан. ургалт 77 хувьтай байна. Мэрэгжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан.4 албан байгууллага өөрийн эзэмшлийн талбайд 557 ш мод, 13 айл өрх 130 ш мод, шинээр тарьсан.Сумын баруун талд шинээр ойн зурвас 1,5 га газа байгуулж 1500 модыг 100 өрхийн 350 иргэн, 3 албан байгууллага, тарьж суулгалаа Иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагыг цахим орчинд уриалж сурталчилан таниулах ажлыг хийсэн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр

Эрүүл мэндийн чиглэлээр:0-18 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж байна. Энэ сард нийт 55 хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.2022.06.08 нд Асгат сумын Их-уулын танилгад зохион байгууллааттай оролцсон. Мөн УИХ гишүүн Ж. Чинбүрэн эмчийн санаачилгаар Белгэ улсаас урилгаар ирсэн 2 нүдний эмчтэй хамтран үзлэг зохион байгуулсан нийт харааны бэрхшээлтэй 58 хүнд үзлэг хийж шил таруулсан 2022 оны 06 сарын 25, 26 өдрүүдэд Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 80 жилийн ойд зориулсан 13 сум, АНЭ, өрхийн эмнэлгүүдийн дунд “Урлагийн наадам” зохион байгуулагдсан. Үүнд байгууллага хамт олнооноо ажилттай оролцож “Гослол хөгжим”-ийн төрөлд 1-р байр их эмч Г. Уранцэцэг эзэлсэн амжилтаар оролцсон.

Боловсролын чиглэлээр:

Хөдөөгийн Дөхөм, Өлзийт багуудад 6-р сарын 10-наас эхлэн 14 хоногийн хугацаатай гэрцэцэрлэг ажиллуулж нийт 31 хүүхдийг хамруулсан

ЕБСурууль:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 9 малчин иргэний төслийг хүлээн авч сумын АДЗ-ийн хурлаар хэлэлцэн болзол хангасан 5 малчин өрхийн төслийг шалгаруулж холбогдох материалыг хүргүүлэн дээд газраас шийдвэрлүүлэн нэг өрхөд 5,0 сая төгрөгний малыг олгосон.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтод бүлгийн 4 иргэнд гэр төслийн амжилттай хэрэгжүүлсэн.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ЯДАМЖАВ.